



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 01/2021

Улаанбаатар хот

Мөнгөн тэтгэмж олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 3.2, 5 дугаар зүйлийн 5.9, Амгалан дулааны станцын Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2021-2022 онд хэрэгжүүлэхээр байгуулсан Хамтын гэрээний 6.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор хөдөлмөр эрхлэлтийн харилцаагаа дуусгавар болгох хүсэлт гаргасан Зуухан цехийн Ашиглалтын хэсгийн Насосны машинч Шагдарсүрэнгийн Мөнхжаргалд эрчим хүчний салбарт 7 жил ажилласан хугацаанд нь ногдох нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгосугай.

2.Ш.Мөнхжаргалд 2021-2022 онд хэрэгжүүлэхээр байгуулсан хамтын гэрээний 6.11 дэх хэсэгт заасны дагуу эрчим хүчний салбарт 7 жил ажилласан хугацаанд нь ногдох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг тооцон олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ